




2005 оноос эрхлэн гаргав.

ЦДҮС ТӨХК-ИЙН ХЭВЛЭЛ
www.transco.mn

ДАМЖУУЛАХ

Сүлжээ



№01 (154) 2023 оны 03 сар

КОМПАНИЙН УДИРДЛАГУУД ШИНЭЭР ТОМИЛОГДОВ

2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлаар Ерөнхий инженер Б.Дашдаваа томилогдсон бол 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Ерөнхий инженерийн үүрэгт ажилд Б.Эрхэмзаяа томилогдож ажлаа хүлээн авлаа. Компанийн шинэ удирдлагууддаа ажлын амжилт хүсье.



“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИАС ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН “ШИЛДЭГ МАСТЕР” ТОДОРЛОО

Эрчим хүчний салбар болон компанидаа 13 жил ажиллаж байгаа Улаанбаатар салбарын Засварын албаны дэд станцын засварын мастер Валягийн Батбаяр 2022 оны эрчим хүчний салбарын шилдэг мастераар шалгарлаа. В.Батбаяртаа компанийн нэрийн өмнөөс халуун талархал илэрхийлж, ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсье!



НҮҮР-3

ТЕСЛА БА ЭДИСОН УРАЛДААНЫ
ШИЛДГҮҮД ШАЛГАРЛАА

НҮҮР-3

2022 ОНЫ ШИЛДЭГ ДЭД СТАНЦААР
«СОНГИНО» ДЭД СТАНЦ ШАЛГАРЛАА

НҮҮР-3

ЗАСВАР, АШИГЛАЛТЫН АЖЛЫН
ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ УРАЛДААНД
ГОВИЙН БҮСИЙН САЛБАР
ТЭРГҮҮЛЛЭЭ

НҮҮР-10


КОМПАНИЙН 2023-2024 ОНЫ
ХАМТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАГДЛАА

НҮҮР-10

КОМПАНИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
«УЛААНБААТАР-2023» СПОРТЫН
ТАВАН ТӨРӨЛТИЙН ТЭМЦЭЭН

НҮҮР-11

«НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ»



2022 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН АВАРГУУД ТОДОРЛОО

2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр компанийн жилийн эцсийн тайлангийн хурал боллоо. Тус хурлаар компанийн “Шилдэг 10 ажил”-аа танилцуулж, хөдөлмөрийн аварга, тэргүүний ажилчдаа шалгарууллаа. “Хөдөлмөрийн аварга”- ИТА-аар Улаанбаатар салбарын РХАХТА-ны ахлах бөгөөд нийлмэл реле хамгаалалт, автотатикийн инженер Д.Төмөр-Очир, “Хөдөлмөрийн аварга”- Шуурхай ажиллагааны инженер техникийн ажилтнаар Хангайн бүсийн салбарын Эрдэнэт дэд станц, салбарын диспетчер инженер Б.Энхтуяа, “Хөдөлмөрийн аварга”-Ашиглалтын монтероор Төвийн бүсийн салбар Борнуур дэд станцын ээлжийн монтер Б.Батсүх, “Хөдөлмөрийн аварга”-Засварын монтероор Говийн бүсийн салбарын Засварын албаны дэд станцын засварын монтер Ө.Отгонзаяа, “Хөдөлмөрийн аварга”-Албан хаагчаар Зүүн-Өмнөд бүсийн салбарын Санхүү, эдийн засгийн албаны цалин хөлсний нягтлан бодогч Д.Сэлэнгэ, “Хөдөлмөрийн аварга”- Ажилтнаар Төв удирдлагын Нийтлэг үйлчилгээ, тээвэр механизмын хэлтсийн суудлын автомашины жолооч П.Отгонбаатар, “Хөдөлмөрийн аварга”-Удирдах албан тушаалтнаар Хангайн бүсийн салбарын ерөнхий инженер Б.Анхбаяр, Төв удирдлагын 2022 оны “Тэргүүний ажилтан”-аар Техникийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн горим тооцооны инженер Б.Амарбаясгалан нар тус тус шалгарлаа. 2022 оны компанийн хөдөлмөрийн аварга, ажилтан албан хаагчдадаа баяр хүргэж, ажлын амжилт хүсье.



“Хөдөлмөрийн аварга”- ИТА Улаанбаатар салбарын РХАХТА-ны ахлах бөгөөд нийлмэл реле хамгаалалт, автотатикийн инженер Д.Төмөр-Очир



Хөдөлмөрийн аварга”- Шуурхай ажиллагааны инженер техникийн ажилтан Хангайн бүсийн салбарын Эрдэнэт дэд станц, салбарын диспетчер инженер Б.Энхтуяа



“Хөдөлмөрийн аварга”-Ашиглалтын монтер Төвийн бүсийн салбар Борнуур дэд станцын ээлжийн монтер Б.Батсүх



“Хөдөлмөрийн аварга”-Засварын монтер Говийн бүсийн салбарын Засварын албаны дэд станцын засварын монтер Ө.Отгонзаяа



“Хөдөлмөрийн аварга”-Албан хаагч Зүүн-Өмнөд бүсийн салбарын Санхүү, эдийн засгийн албаны цалин хөлсний нягтлан бодогч Д.Сэлэнгэ



Хөдөлмөрийн аварга”- Ажилтан Төв удирдлагын Нийтлэг үйлчилгээ, тээвэр механизмын хэлтсийн суудлын автомашины жолооч П.Отгонбаатар



“Хөдөлмөрийн аварга”-Удирдах албан тушаалтан Хангайн бүсийн салбарын ерөнхий инженер Б.Анхбаяр



Төв удирдлагын 2022 оны “Тэргүүний ажилтан” Техникийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн горим тооцооны инженер Б.Амарбаясгалан

ТЕСЛА БА ЭДИСОН УРАЛДААНЫ ШИЛДГҮҮД ШАЛГАРЛАА

Ажилтнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, оновчтой санал бүтээлийг дэмжиж урамшуулах Тесла ба Эдисон уралдааны “Шилдэг төсөл” төрөлд “Хэмнэлт” төсөл боловсруулсан Улаанбаатар салбарын диспетчер инженер Ц.Баттогтох удирдагчтай, диспетчер инженер Ц.Миеэсүрэн, Э.Хатанбаатар, Р.Алдаржавхлан, Г.Оюундэлгэр Б.Даваасамбуу, Б.Баянжаргал, Н.Батсүрэн, Д.Чойжамц нарын бүрэлдэхүүнтэй нэгдүгээр байрыг эзэлж Тесла цом өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан бол дэд байрт “Төсвийн программ хангамж”-ийг боловсруулсан Хангайн бүсийн салбарын горим, баланс тооцоо, хэмнэлтийн инженер Л.Оюунномин шалгарлаа.



Тесла ба Эдисон уралдааны “Шилдэг төсөл” төрөлд тэргүүн байр эзэлсэн “Хэмнэлт” төсөл боловсруулсан Улаанбаатар салбарын диспетчер инженер Ц.Баттогтох баг хамт олноо төлөөлж шагнал гардаг буй мөч



Тесла ба Эдисон уралдааны “Шилдэг төсөл” төрөлд дэд байр эзэлсэн “Төсвийн программ хангамж”-ийг боловсруулсан Хангайн бүсийн салбарын горим, баланс тооцоо, хэмнэлтийн инженер Л.Оюунномин



Тесла ба Эдисон уралдааны “Шилдэг бүтээл” төрөлд тэргүүн байрыг эзэлсэн “Дэд станцын синхрон цагийн төхөөрөмж”-ийг зохион бүтээсэн Улаанбаатар салбарын РХАХТА-ны ахлах бөгөөд реле хамгаалалт, автоматикын инженер Д.Төмөр-Очир баг хамт олноо төлөөлж шагнал гардаг буй мөч



Тесла ба Эдисон уралдааны дэд байрыг эзэлсэн “Трансформаторын коэффициент хэмжигч багаж к-5” бүтээлийг зохиосон Төвийн бүсийн салбарын “Трансформаторын коэффициент хэмжигч багаж к-5” бүтээлийг зохиосон Төвийн бүсийн салбарын өндөр хүчдэлийн туршилт хэмжилтийн инженер М.Норовсамбуу баг хамт олноо төлөөлж шагнал гардаг буй мөч

ЗАСВАР, АШИГЛАЛТЫН АЖЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ УРАЛДААНД ГОВИЙН БҮСИЙН САЛБАР ТЭРГҮҮЛЛЭЭ


Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын ашиглалтын түвшинг дээшлүүлэх, засварын ажлын чанар, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулан ажлын хариуцлага сахилга бат, урам зоригийг дээшлүүлэн ажилтнуудад зэрэг хандлага төлөвшүүлэх талаар тодорхой үр дүнд хүрсэн салбар, хамт олныг үнэлж урамшуулах зорилготой “Засвар, ашиглалтын ажлын чанарыг дээшлүүлэх уралдаан” 3 дахь жилдээ явагдлаа. Засвар, ашиглалтын ажлын чанарыг дээшлүүлэх энэ жилийн уралдаанд Говийн бүсийн салбар тэргүүлээ. Говийн бүсийн салбарын хамт олонд ажлын амжилт хүсье.



2022 ОНЫ ШИЛДЭГ ДЭД СТАНЦААР “СОНГИНО” ДЭД СТАНЦ ШАЛГАРЛАА



Компанийн “Ажлын байрны соёл-5С” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэвшүүлэх, үнэлэх журмын 4 дүгээр зүйлийн 4.14 дэх хэсэгт заасны дагуу “Ажлын байрны соёл-5С” хөтөлбөрийн Удирдлагын баг 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн “Ажлын байрны соёл-5С” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн 2022 оны “Шилдэг дэд станц”-уудыг шалгарууллаа. “Шилдэг дэд станц” номинацын нэгдүгээр байрыг Улаанбаатар салбарын “Сонгино” дэд станц эзэлсэн бол дэд байранд Хангайн бүсийн салбарын “Хархорин” дэд станц шалгарч, гуравдугаар байрт Говийн бүсийн салбарын “Даланзадгад” дэд станц удааллаа.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЖУУХ БИЧИГ, САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН ЦОЛ ТЭМДГЭЭР ШАГНАГДЛАА



Мэдээллийн технологийн хэлтсийн ахлах Ч.Нэргүй

Айлчлан ирж буй шинэ оны босгон дээр “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-иас “Эрчим хүчний яамны жуух бичиг”-ээр 2, “Эрчим хүчний тэргүүний ажилтан” цол тэмдгээр 2 ажилтан тус тус шагнагдлаа. “Эрчим хүчний яамны жуух бичиг”-ээр Засвар зохицуулалт, төслийн хэлтсийн төсөл хөтөлбөрийн инженер Ч.Одбаяр, тус хэлтсийн гагнуурчин Н.Мэнд-Амар нар шагнуулсан бол “Эрчим хүчний тэргүүний ажилтан” цол тэмдгээр Захиргаа удирдлагын хэлтсийн орон тоо, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Д.Шүрмаа, Мэдээллийн технологийн хэлтсийн ахлах Ч.Нэргүй нар энгэрээ мялаалаа.



Засвар зохицуулалт, төслийн хэлтсийн төсөл хөтөлбөрийн инженер Ч.Одбаяр, тус хэлтсийн гагнуурчин Н.Мэнд-Амар



Захиргаа удирдлагын хэлтсийн орон тоо, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Д.Шүрмаа

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 100 ЖИЛИЙН ОЙН СПОРТЫН ИХ НААДАМД ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН БАГ ТАМИРЧИД ТЭРГҮҮЛЖ, АВАРГЫН АЛТАН ЦОМЫН ЭЗЭН БОЛЛОО



Монгол Улсад эрчим хүчний салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан спортын их наадам 2022 оны 09.07-09.12-ны өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Тус наадамд эрчим хүчний 45 байгууллагын 1200 гаруй тамирчин спортын 6 төрлөөр /Сагсан бөмбөг, Волейбол, Ширээний теннис, Дартс, Шатар, Олс таталт/ хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн баг тамирчид нийт 99 оноогоор тэргүүлж, аваргын алтан цомын эзэн боллоо. Сагсан бөмбөгийн тэмцээний эрэгтэй, эмэгтэй ангилалд алтан медаль, Волейболын эмэгтэй ангилалд алтан медаль, эрэгтэй ангилалд мөнгөн медаль, Олс таталтын тэмцээнд багаараа хүрэл медаль, Шатрын эрэгтэй, эмэгтэй ангилалд алтан медаль, Ширээний теннисний эмэгтэй ангилалд алтан медаль, эрэгтэй ангилалд мөнгөн медаль, Дартсын тэмцээнд тусгай байрыг тус тус эзэлсэн юм. Мөн волейболын шилдэг эмэгтэй тамирчнаар Төсөл хөтөлбөрийн хэлтсийн ПХБ-ийн монтёр Б.Энхзаяа, Сагсан бөмбөгийн шилдэг эмэгтэй тамирчнаар ХМХ-ийн техникийн хяналтын инженер Д.Ганзуул, Ширээний теннисийн шилдэг эмэгтэй тамирчнаар Б.Мөнгөнцэцэг нар шалгарсан бол спортын дэд мастер цолоор Улаанбаатар салбарын РХАХТ-ын албаны хэмжүүрийн засварын тохируулгын техникч Ч.Даваажаргал шагнагдлаа. Салбарын спортын их наадамд амжилттай оролцсон ажилтан, албан хаагч тамирчдаадаа спортын болон ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ ТӨХК-ИЙН АХМАДЫН ХОРООНЫ ДАРГААГ Л.ДАРАМБАЗАР ТОМИЛОГДЛОО



2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Ц Д У С - ТӨХК - и й н ахмадын хорооны даргаар Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан Л.Дарамбазар томилогдож ажлаа хүлээн авлаа.

Л у в с а н д о р ж и й н Дарамбазар 1944 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Дундговь аймгийн Говь-Угтаал суманд төрсөн. Ташкентын ХАА-ийн цахилгаанжуулалт, механикжуулалтын инженерийн дээд

Аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одон, Ардын хувьсгалын 50, 60, 70, 80 жилийн ойн медаль, Эрчим хүчний тэргүүний ажилтан цол тэмдгээр тус тус шагнагдсан.

Эрчим хүчний салбарт ажиллаж эхэлсэн цагаас хойш Улаанбаатар хотын цахилгаан шугам сүлжээний газрын ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, Нийслэл хотын цахилгаан хангамжийг найдваржуулах, эрчим хүчний салбарыг хөгжүүлэх их үйл хэрэгт бүхий л мэдлэг авьяас чадвараа зориулан ажилласан. Ажилчдын нийгмийн асуудалд түлхүү анхаарч 144 айлын орон сууц, дүүргийн эрчим хүчний салбар бүрт ажлын шинэ байруудыг барьж, ажилчдын амьдралын болон ажлын байрны нөхцөлийг шийдвэрлэсэн. Үйлдвэрлэлийн зохион байгуулал, шугам тоноглолын болон холбооны найдваржилтыг дээшлүүлэх, схемийг сайжруулах, зардал хэмнэх, аюулгүй ажиллагааг хагнах чиглэлээр улсын бүртгэлтэй 10 гаруй оновчтой санал гарган нэвтрүүлж, 10-аад төсөл боловсруулан хэрэгжүүлсэн нь одоог хүртэл үр ашгаа өгсөөр байна.

Цахилгаан шугам сүлжээний техник эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, тоноглолын ашиглалт, засварын чанарыг дээшлүүлэх, цахилгаан хангамжийг сайжруулах, найдвартай ажиллагааг хангах чиглэлээр техникийн ашиглалтын паспорт заавар, гарын авлага, стандарт, төсөл эрдэм шинжилгээ судалгааны өгүүлэл оновчтой саналын 60-аад бүтээл туурвисан бид бүхний бахархал болсон ахмад үеийн төлөөлөл билээ.

сургууль, Эдийн засгийн мэдлэгийн ардын их сургууль, Удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх институт тус тус төгссөн.

Цахилгааны инженер, Техникийн ухааны магистр, зөвлөх инженер, эдийн засагч, 1970-1982 онд Улаанбаатар цахилгаан шугам сүлжээний газар монтёр, диспетчер инженер, Дамжуулах сүлжээний цех, үйлдвэр техникийн хэлтсийн дарга, 1982-1990 онд ерөнхий инженер, 1990-1996 онд газрын дарга, хяналтын инженер, 2001 оноос Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн Ашиглалт засварын албаны дарга, Нэг худалдан авагчтай загвар хэрэгжүүлэх хэлтсийн даргаар ажиллаж байсан.

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН АХМАДЫН ХОРООНЫ БҮТЭЦ



Жич: Ахмадын хорооны үйл ажиллагааны журмыг 12-р нүүрээс үзнэ үү.

УЛААНБААТАР САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Улаанбаатар салбарын 2023 оны төлөвлөгөөт засварын ажил эхэлж байгаагаар холбогдуулан ажилтнуудад мэдээлэл хийж засварын ажлын зорилго чиглэл, анхаарах зүйлсийн талаар уулзалт, ярилцлага хийж, сургалт зааварчилгаа явуулсан.



Зааварчилгаа өгч байгаа байдал

Мөн өдөрлөгийн үеэр “Тесла, Эдисон” уралдаанд амжилттай оролцсон салбарын ажилтнууд бүтээлүүдийнхээ талаар танилцуулав.



Өдөрлөгийн үйл ажиллагаа

Түүнчлэн эрүүл ахуйн чиглэлээр “амны хөндийн эрүүл ахуй, шүд цоорох өвчин ба шалтгаан түүнээс урьдчилан сэргийлэх, шүд угаах арга техник” сэдвээр “Болордент” эрүү нүүр амны эмнэлгийн эмч нар сургалт, танилцуулга болон ажилтнуудад амны хөндийн үзлэг хийв.



Өдөрлөгийн үйл ажиллагаа

“Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм”-ийн дагуу 2023 оны 1 дүгээр улирлын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 3 дугаар шатны үзлэгийг 15 дэд станцад явуулсан.



Өдөрлөгийн явц

АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС

Компанийн ерөнхий инженерийн баталсан удирдамжийн дагуу цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурвасын дэглэм сахиулах ажлын хүрээнд 152 айл өрх, 116 аж ахуйн нэгжүүдэд албан мэдэгдэл тараав.

110/10/6 кВ-ын Дундгол дэд станцын 10,6 кВ-ын нийт 21 нэр төрлийн таслууруудын их засварын ажил хийгдэж байна.



ЭЭЛЖИТ БОЛОН ЭЭЛЖИТ БУС СУРГАЛТУУД

УБС-ын 2023 оны танхимын ээлжит сургалтыг батлагдсан хөтөлбөр хуваарийн дагуу 2023 оны 03 дугаар сарын 18-25-ны хооронд Монголын үндэсний их сургуулийн сургалтын зааланд зохион байгуулсан. Сургалтад нийт 358 ажилтан хамрагдсан.



АХМАДУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Сар шинийн баярыг тохиолдуулан салбарын ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулав. Арга хэмжээнд 95 ахмад настан оролцсон.



220 КВ-ЫН 203, 204-Р ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМД ГАРСАН АВААРЫН ДАРААХ СЭРГЭЭН БОСГОЛТЫН АЖИЛ

Тус салбарын Засварын албаны дарга В.Мөнхбатаар ахлуулсан шугамын засварын бригад 2023 оны 01-р сарын 24-ний өдөр тасралтын мөрөөр ээлжит бус үзлэг хийхэд Төв аймгийн Аргалант сумын 2-р багт байрлах 220 кВ-ын 203, 204-р ЦДАШ-ын тулгуур №68 хугарч унасан, (ПС220-2Т маркийн төмөр) траверсууд гэмтэж, дамжуулагч утас тасарсан байсан.

Гэмтлийн шалтгаан нь хүйтний эрч эрс чангарч, төвийн бүс нутгаар шөнөдөө -33-41 градус, өдөртөө -22-27 градус, гадна орчны агаарын температур огцом буурсны улмаас 220 кВ-ын 203 дугаар агаарын шугамын тулгуур №68-69 хооронд С фазын АС-400/51 маркийн дамжуулагч утас чангарч, механик таталтын хүч үйлчлэн тулгуур №67-68 хооронд С фазын дамжуулагч утас холбосон САС-500-1 маягийн залгаасны утасны ган тросс шувтарсан нь утас тасрах болон дамжуулагч утас тасарснаас тулгуур №67-68-д үүссэн чичиргээт эргэлтийн моментын хүчийг ПС-220-2Т маркийн №68 дугаар тулгуурын их биеийн төмөр хийц даалгүй гулзайлт үүсэж нумарснаас 6 траверс, аянгын тросс тогтоогч бүхий дээд хэсэг тасарч, дамжуулагч утас тал руу газарт унасан нь гэмтэл гарах үндсэн шалтгаан болсон.

Хуучин тулгуур №50-г буулгаж зөөвөрлөн тулгуур №68-н сууринд сэргээн босгох, 6 фазын утас татах, аянгын тросс татах зэрэг ажил хийгдэж, 2023 оны 01-р сарын 26-ны өдрийн 18:32 цагт хүчдэлд залгагдсанаар гэмтэл устгах ажил бүрэн дууссан.




Тулгуур №68 гэмтсэн байдал



Шинээр тулгуур босгох ажлын явц


2023 оны 03-р сарын 09-ний өдрийн орой ГБС-ын 215, 216-р АШ-ын тулгуур №32 унасан, тулгуур №30, 31-н гуя төмөр гулзайсан аваар гарч, УБС-ын Засварын албаны ахлах бөгөөд засварын инженер С.Ариунбатаар удирдуулсан бригад унасан тулгуур зөөвөрлөх, трасс цэвэрлэх ажил, шугамын засварын инженер М.Мөнгөн-Эрдэнээр удирдуулсан бригад шугамын утас буулгах, тулгуур босгох ажлыг 2023 оны 03-р сарын 09-11-ний өдрийг дуустал Засварын албаны нийт 22 ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллаж, аваар саатлыг хурдан хугацаанд устгаж ажилласан.



ТӨВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

2023 оны ээлжит шалгалтыг цахимаар тест бөглөх, хариулт сонгох хэлбэрээр зохион байгуулсан. Их дээд сургуулийн сургалтад ашиглагдаж байгаа Moodle программыг ашиглан нийт 132 ажилтанаас нэг цаг хугацаанд нэгэн зэрэг ААД, ТАД-ийн шалгалт, техникийн бус 34 ажилтнаас ААД болон холбогдох хууль дүрэм журмаар шалгалт авсан нь онцлог байлаа. Сургалтын Moodle программд ААД-ийн 530 тест, ТАД болон ХАБЭА тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам, Салбарын үндсэн дүрэм, Эрчим хүчний ЦШС хамгаалах дүрэм чиглэлээр нийт 332 тестийг шинээр боловсруулж энэхүү программд оруулж өгсөн.



ЦДҮС ТӨХК 2023 онд “ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛСАН ЭРҮҮЛ АЖЛЫН БАЙР” уриалга гаргасан. Энэхүү ажлын хүрээнд салбартаа ХАБЭА тухай хууль, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ, АЮУЛЫГ МЭДЭЭЛЭХ ХУУДАС сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн алба тус бүр нь ажлын онцлог үйлчлэх бүсийн хүрээнд эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийж байгаа ба 2023.03.25-ны байдлаар АШҮА, ЗА, РХАХТА-ны нийт 20 нэр төрлийн эрсдэлийн үнэлгээг хийгээд байна.

ХАБЭА-ийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт болон ажилтаны эрх, үүрэг хариуцлагыг сурталчлан таниулах мөн ажлын байранд учирч болзошгүй аюул

эрсдлийг арилгах, цаг алдалгүй бүртгэн мэдээлэх талаар ХАБЭА инженерүүд нийт ажилтануудад сургалт явуулсан.

Ийнхүү ажлын байр болон ажилбар бүр дээр эрсдэлийн үнэлгээг хийснээр болзошгүй аваар саатлаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг хяналтандаа авч удирдах мөн хийх ажлын агуулга, үйлчлэх хүрээ, ажил гүйцэтгэх технологи дарааллыг бүрэн ойлгохоос гадна зааварчилгаа нь чанартай болох зэрэг олон давуу талтай юм. Салбарын бүх ажилтнууддаа эрсдлийн үнэлгээ хийх загвар хүснэгтийг боловсруулж гарган сургалт зөвлөмжийг 3 удаа хийсэн.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

ЗАСВАРЫН ЗӨВЛӨГӨӨН

Төвийн бүсийн салбар нь 2023-2024 оны өвлийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 2023 онд хийгдэх ИЗ, ТЗБАХ, УЗ-уудын ажил тус бүрийн ажил гүйцэтгэх төлөвлөгөө /АГТ/, график төлөвлөлт, хоног хугацаа, ажлын байр бэлтгэх хүлээн авах, өвлийн их ачааллын үеийн тоноглолын халалт хэмжилт, засварын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл, засвар зохион байгуулалт, илэрсэн гэмтэл зөрчил устгах, салбарын аюулгүй байдал хариуцагч нарийн тушаалын төсөл танилцуулах, ээлжит бус зааварчилгаа өгөх, салбарын тоноглолын шинэчлэл хүрээнд хийгдсэн судалгаа танилцуулах зэрэг чиглэлээр ЗААА, ИА, АШҮА, РХАХТА, ТМХ, ЗА нийт 50 орчим ИТА нарын дунд 3-р сарын 03-ны өдөр хурлын зааланд засварын зөвлөгөөн 2023 амжилттай зохион байгуулан ойрын хугацаанд засварын зохион байгуулалтын хүрээнд хийгдэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөгөө гарган засварын ажиллаа эхлүүлээ.



УРСГАЛ ЗАСВАРААР ХИЙГДСЭН АЖИЛ

- 2023.03.06-20-ны хооронд 110/6кВ Давхар дэд станцын 2023 оны ээлжит урсгал засварын ажлыг батлагдсан графикайн дагуу хийж гүйцэтгэсэн. Т-1,2 болон 6 кВ-н СХТ, гарсан шугамуудад засвар үйлчилгээ хийн, реле хамгаалалтын ажиллагааг тавил болон схемийн дагуу ажиллуулан шалгасан. Бүх холболтуудын микропроцессорын реленүүд болон RTAC-д тохиргоо хийн алсаас тасалж залгах боломжтой болгосон.
- 110/6 кВ-ын Бурхант дэд станцын реле хамгаалалтын урсгал засварын ажлыг 2023.03.06.20-ны хооронд графикайн дагуу хийж гүйцэтгэсэн.
- 110/6кВ Бурхант дэд станцын хэмжүүрийн урсгал засварын ажлыг 2023.03.07-14-ны хооронд графикайн дагуу хийж гүйцэтгэсэн.




СУРГАЛТ БҮТЭЭМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Ажлын байран дахь үйлдвэрлэлийн ослын статистикаар өндрөөс унаж амиа алдсан, хүнд хөнгөн гэмтэж бэртсэн тохиолдлууд эхний байранд жагсаж байгаа учир ажилчид өндөрт ажиллах бүрт өндрөөс унах эрсдэлийг хамгийн бага хэмжээнд байлгах системээр инженер, техникийн ажилтнуудад өндрийн аюулгүй ажиллагаа, уналтаас хамгаалах, уналт сэргийлэх, уналтаас хамгаалах талаар өндрийн сургалтыг төрөлжүүлэн мэдлэг олгохоор Засварын албаны ЦДАШ-н монтеруудын 2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу “Өндрийн ажил мэргэжлийн холбоо” Төрийн бус байгууллагатай хамтран “Өндөрт ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагаа ба аврах аргачлал” сэдвээр 3-р сарын 13,14-ний өдрүүдэд нийт 16 цагийн гэрчилгээт сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Сургалтад Засварын албаны ЦДАШ-н 9 ажилтан ур чадвар ба онолын сэдвээр сорил шалгалтад хангалттай үнэлгээ авсан.



АШҮА-ны Төвийн хэсгийн 6 дэд станцын ажилтанууд Дархан-уул аймгийн онцгой байдлын газартай хамтарч галын эсэргүүцэх дасгалыг 110/6 кВ-н Давхар дэд станц дээр явуулсан. Дасгал нийт 35 ажилтанд хамрагдсан.





ХАНГАЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 01, 02-р саруудад дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Ээлжит шалгалтын талаар: Салбарын нийт ажилтнуудын 2023 оны ААД, ТАД-ийн мэдлэгийн ээлжит шалгалтыг 02 дугаар сарын 01-ний өдрөөс 02 сарын 17-ны өдрүүдэд дүрэм, зааврууд, холбогдох хууль тогтоомжууд болон ээлжит сургалтын материалуудаас бэлтгэсэн асуултыг ашиглан ААД-ийг тест хэлбэрээр, ТАД-ийг бичих хэлбэрээр авлаа. Ээлжит шалгалтад салбарын нийт 138 ажилтан хамрагдаж 92,8 %-ийн амжилттайгаар шалгагдлаа.

Наряд, шийдвэрээр хийсэн ажлын талаар: Салбарын харьяа нийт 12 дэд станцын тоног төхөөрөмжүүд болон 110кВ, 220кВ-ын ЦДАШ-уудад нарыаар 31, шийдвэрээр 112 удаагийн ажил гүйцэтгэж, зөрчил дутагдалгүй ажиллалаа.

Ажил гүйцэтгэх бригадуудын нийт 393 ажилтанд тухайлсан зааварчилгааг өгч ажилласан байна.

Дасгал, зааварчилгааны талаар: Салбарт шинээр ажилд орсон 7 ажилтанд урьдчилсан зааварчилгааг, 7 ажилтанд ажлын байрны анхан шатны зааварчилгааг, 3289 ажилтанд өдөр тутмын зааварчилгааг, 227 ажилтанд

сар бүрийн ээлжит зааварчилгааг, ээлжит бус зааварчилгааг 206 ажилтанд, тухайлсан зааварчилгааг 624 ажилтанд тус тус өгч ажилласан байна.

Салбарын алба, хэсэг, дэд станцууд дээр аваар эсэргүүцэх дасгал 7 удаа хийгдэж нийт 68 ажилтан, гал эсэргүүцэх дасгал 4 удаа хийгдэж, нийт 42 ажилтан, осол эсэргүүцэх дасгал 5 удаа хийгдэж, нийт 77 ажилтан тус тус хамрагдсан байна.

ХАБЭА-н бүх шатны үзлэгийн талаар: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг давхардсан тоогоор 83 удаа хийж 154 зөрчил, II шатны үзлэгийг 18 удаа хийж, 66 нэрийн зөрчлийг илрүүлэн устгах арга хэмжээг авч ажиллалаа.

ХАБЭА-н III шатны үзлэгийг салбарын ерөнхий инженер Б.Анхбаяр ахлагчтай комисс салбарын харьяа 11 дэд станцад 01 сарын 16-аас 02 дугаар сарын 15-ны өдрүүдэд хийж, нийт 86 нэрийн зөрчлийг илрүүлэн хугацаатай үүрэг даалгавар устгуулан ажиллалаа.

Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг 32 удаа хийж 11 нэрийн зөрчлийг илрүүлэн устгалаа. Салбарын харьяа ажлын байруудад ашиглагдаж байгаа нийт гал унтраагууруудын хяналтын картыг шинэчлэн нэг загварт оруулж, бүх дэд станцууд ажлын байруудад байрлуулан,

үзлэг шалгалтын тэмдэглэгээг сар бүр хийн ажиллаж байна.

Бусад ажлын талаар: Салбарын үйлчлэгч, тогооч нарын ажлын тусгай хувцсыг 6 ажилтанд, шинээр орсон 1 ажилтанд зуны нормын хувцсыг хуваарилж олгосон.

Дэд станцуудад нүд хамгаалах тунгалаг шил 26ш, 110кВ-ын зөөврийн газардуулга 2ш, хүчдэл заагчууд 6ш тус тус II/13-ны өдөр хуваарилсан.

110/35/10кВ-ын Хархорин дэд станцын өргөтгөлийн ажлын явцтай II/05, III/01-ний өдрүүдэд салбарын ерөнхий инженертэй хамтран газар дээр нь хяналт шалгалтыг хийсэн.

“Хамгаалалтын зурвас”-ын дэглэм сахиулах ажлын хүрээнд салбарын хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө гарган баталгаажуулж алба хэсэг, дэд станцуудад үүрэг чиглэл өгөн ажиллаж байна.

Компани болон бусад газраас ирсэн сэрэмжлүүлэх мэдээлэл даалгавруудыг цаг тухай бүрт нийт ажилтнуудад танилцуулж ээлжит бус зааварчилгааг өгөн ийм төрлийн гэмтэл зөрчлийг давтан гаргахгүй байх талаар анхааруулан, шаардлагатай төлөвлөгөө, зааварчилгааг гарган ажиллаж байна.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

ГЭМТЭЛ УСТГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖЛУУД:

- 2023.02.08-ны өдөр 110 кВ Цэцэрлэг АШ-н 329 тулгуурын 1-р утас Хархорин талын ГВН угаар 18 судал тасарсан гэмтлийг Засварын мастер Б.Чагнаадоржийн бригад устгав.
- 2023.02.08-ны өдөр 220кВ-ын 203,204 ЦДАШ-ын гэмтэл устгах ажлыг Д.Болдбаатар ажлын удирдагчтай Г.Баттөмөр ажил гүйцэтгэгчтэй 12 хүний бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэв. Үүнд:
- 203-р АШ Т№428-427-н хооронд С-фазын 53-н жийл тасарсаныг АС-400 10м оруулга оруулж, 2ш САС-400/35, 2ш Ган гилц ЖУВ-400/35 шахаж залгаа хийж хэвийн болгов Т№401-402 хооронд аянтын троссны залгааны 2 талаар 18ш жийл тасарсаныг таталтын зажим NBN-3 аар 2 талд нь бэхэлгээ хийсэн
- 204-р АШ-н Т№450-451 хооронд аянтын троссны залгааны 2 талаар 18ш жийл тасарсныг таталтын зажим NBN-3 аар 2 талд нь бэхэлгээ хийсэн
- 2023.02.16-ны өдөр 110 кВ-ын Арвайхээр ЦДАШ-ын тулгуур №47, 49-т утасны гэмтэл устгах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:
- Тулгуур №47-46 хооронд I фазын дамжуулагч утасны ЧН-ийн угаар 19 судал тасарсан гэмтэлд 50 м оруулга хийв.
- Тулгуур №49-48 хооронд II фазын дамжуулагч утасны залгааны угаар 5 судал тасарсан гэмтэлд ороолт хийв.
- 2023.02.17-ны өдөр ашиглалтын инженер Б.Хонгорзул ажлын удирдагчтай 7 хүний бүрэлдэхүүнтэй бригад 110 кВ-ын Баянхонгор ЦДАШ-ын Анкер №805, 806, тулгуур №807 утасны гэмтэл устгах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:
- Анкер №805 II фазын дамжуулагч утасны ЧН-ийн угаар 13 судал, давхар ЧН дотроо 8 судал тасарсанд 30 м оруулга хийв.
- Анкер № 806 III фазын дамжуулагч утасны ЧН-ийн угаар 5 судал тасарсанд ороолт хийв.
- Тулгуур №807 II фазын залгааны угаар 8 судал тасарсанд ороолт хийв.
- 2023.02.18-ны өдөр 110 кВ Мөрөн-Тэлмэн АШ тулгуур №265 III фазын дамжуулагч утас 8-12 судал тасарсан гэмтэл устгах ажилд АУ -Д.Алтанхуягийн 6 хүнтэй бригад хийж гүйцэтгэв.

СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Салбарын ажилтнуудын нэгдсэн сургалтыг 2023 оны 01-р сарын 18-аас 20-ны өдрүүдэд Эрдэнэтэд зохион байгуулав. Сургалтын хөтөлбөрт:



- Хагас дамжуулагч материалууд ба тэдгээрийн хэрэглээний чиг хандлага
- /Доктор (Ph.D), дэд профессор Г.Бэхбат/
- Газардуулах байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээ, хэмжилт хийх, сайжруулах аргачлал /Доктор (Ph.D), дэд профессор Г.Бэхбат/
- Замын хөдөлгөөний дүрэм /Есөн хайрхан жолооны курсийн багш Ц.Бадарч/
- 110/220 кВ-ын Цахилгаан дамжуулах агаарын шугамын РХА
- /РХАХТХ-ийн ахлах бөгөөд НРХА-ийн инженер З.Батзориг/
- Трансформаторын хамгаалалт, Шинийн хамгаалалт /РХАХТА-ны дарга М.Энхтайван/
- Амьдралын зөв хэв маяг, хорт зуршлаас татгалзах /Залуучуудын хөгжлийн газар Б.Отгонхишиг/
- Нэгдсэн сүлжээний дүрмийн холбогдох заалтууд /Албаны ахлах бөгөөд АШҮ-ний инженер Ж.Анхбаяр/
- Нэгдсэн сүлжээнд гарсан аваар устгах, цахилгаан хуваарилах байгууламжид сэлгэн залгалт хийх заавруудын эмхэтгэл /АШҮА-ны дарга А.Гомбосүрэн/
- Шинээр мөрдөгдөх хууль тогтоомжууд
- Дэд станцын тоноглолуудын ашиглалт, засвар Ашиглалтын инженер Л.Отгонбаяр
- Цахилгаан дамжуулах агаарын шугамын ашиглалт, засвар, Засварын албаны дарга Ч.Анхдаваа
- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тухай хууль
- Хувь хүний хөгжил, цагийн менежмент Зөвлөх инженер Ё.Ариунаа
- ХАБЭА-н тухай, ХАБЭА-н менежментийн систем, эрсдэлийн үнэлгээ ХАБ-н сургагч багш П.Бат-Өлзий
- Томилолтын журам, цалин хөлс бодох аргачлал /Эдийн засагч Д.Отгонбаатар, Нягтлан бодогч М.Золжаргал/


ОНЦЛОХ АЖИЛ

110/35/10кВ-ын Хархорин дэд станц дээр Дэлхийн банкны төслийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй /Төсөл захиалагч Эрдэнэт-Үйлдвэр-ТӨҮГ/, /Төсөл хэрэгжүүлэгч “Richwell LLC”/, “ӨӨРӨӨ НУНТАГЛАХ ХЭСГИЙН ӨРГӨТГӨЛИЙН ГАДНА ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ХҮРЭЭНД 110кВ-ын СИСТЕМ ШИН 15МВА-ЫН ХҮЧИН ЧАДАЛТАЙ ХҮЧДЭЛ ТОХИРУУЛГЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАХ” Төслийн хүрээнд 16МВА-ын чадалтай 110/10кВ-ын трансформатор, 10кВ-ын шунтлагч реактор, 110кВ-ын таслуур, салгуур, гүйдэл, хүчдэлийн трансформатор, 110кВ болон 10кВ-ын цэнэг шавхагч, аянга зайлуулагч, 10кВ-ын ячеик, тоноглолуудын удирдлага болон хамгаалалт мөн SVG төхөөрөмжийн модулиуд суурилсан контейнер зэргээс бүрдсэн 110кВ-ын нэг ком ячеик баригдсан өргөтгөлийн ажил хийгдэж байна. Мөн НМГ удирдлагыг контейнер болон ОПУ-ын хооронд шилэн кабелиар холбон диспетчерийн өрөөнд дэлгэцнээс бүх тоноглолыг удирдахаар төхөөрөмжилж өгсөн байгаа. Уг ажлын гүйцэтгэл нь 90%-тай явж байгаа ба 3-р сарын 22-ны өдөр техникийн комисс ажиллана.



Өргөтгөлийн ажил





ЗҮҮН-ӨМНӨД БҮСИЙН САЛБАР

ХАБЭА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын алба, хэсэг, дэд станцуудад сар бүр батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа бүх төрлийн дасгалын явц, түүний чанар, зааварчилгааны мөрдөлтөд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

2023 оны эхээс урьдчилсан зааварчилгаанд шинээр ажилд орсон 11 ажилтан, сарын давтан зааварчилгаанд 321 ажилтан, ээлжит бус зааварчилгаанд 265 ажилтан, өдөр тутмын давтан зааварчилгаанд 4095 ажилтан давхардсан тоогоор тус тус хамрагдаад байна.

2023 оны мэдлэгийн ээлжит шалгалт, давтан шалгалт авах ажлыг 2023 оны 02 дугаар сарын 06-наас 03 дугаар сарын 01-ний хооронд ААД, ТАД, НСД, аваар устгах эмхэтгэл, болон бусад хууль, дүрэм журам, АШ-ын трассын схем, ША-ны схем

зурах, сэлгэн залгалт, наряд бичих бичгийн хэлбэрээр зохион байгуулж салбарын харьяа алба, хэсэг, дэд станцуудын нийт 170 ажилтан хамрагдаж, 100%-ийн амжилттай шалгагдсан ба 2023 оны ажлын аюулгүй байдлыг хариуцагч нарын тушаалыг батлуулж гаргуулсан.

2023 оны 1-р улирлын ХАБЭА, ашиглалт засварын III шатны үзлэгийг 2023 оны 02 сарын 06-наас 2023 оны 03 сарын 06-ны өдрүүдэд салбарын хэмжээнд зохион байгуулж нийт 66 зөрчил илрүүлж түүнийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. 2022 оны 4-р улирлын ХАБЭА-н III шатны үзлэгийн гүйцэтгэл 99.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2023 оны “Хамгаалалтын зурвас”-ын дэглэм сахиулах аяны хүрээнд компанийн

ерөнхий инженер Б.Эрхэмзаяагийн 2023 оны 03 сарын 14-ний өдөр ирүүлсэн удирдамжийн дагуу салбарын хэмжээнд хийгдэх 10 ажилбар бүхий төлөвлөгөөг гаргаж батлуулан 2023 оны 03 сарын 15-ны өдрөөс 05 сарын 12-ны хооронд зохион байгуулахаар ажиллаж байна.

2023 онд компанийн хэмжээнд гарсан сэрэмжлүүлэх мэдээлэл даалгавар №01, 02, компанийн ҮЭХ-ны нэрэмжит 5 төрөлт тэмцээнд оролцож байгаа баг тамирчид, ГБС-т гарсан аваарыг устгах засварын бригад, хуваарилах байгууламж дэд станцын шуурхай ажиллагааны монтер, засварын монтеруудын чадамжийн гэрчилгээ олгох сургалтад хамрагдаж байгаа ажилтнуудад ээлжит бус тухайлсан зааварчилгаанууд өгөхөөс гадна, 6-8 цагийн мэргэжлийн хичээлийг тогтмол зааж ажилласан байна.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

Засварын чиглэлээр:

Засварын ажлын мэдээ: 2023 оны 03 сарын 21-ний байдлаар Ашиглалтын түвшин үзлэг үйлчилгээний давхардсан тоогоор 54 ажлыг 1,8 сая төгрөгөөр, Гэмтэл устгалын өссөн дүнгээр 17 ажлыг 2,2 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгээд байна.

Гэмтэл устгах ажлаар: 2023 оны I улиралд дараах гэмтэл устгах ажлуудыг зохион байгуулж хийсэн байна. Үүнд:

Төв дэд станц руу контороос явсан интернэтийн шилэн кабелийн гэмтлийн тодорхойлж, 200 м шилэн кабель сольж залгаа хийх ажлыг төв компанитай хамтарсан бригад зохион байгуулж хийсэн.

110/35/6 кВ-н Бор-Өндөр дэд станцад яч №32 6кВ-н ЦРП-1-н нэвтрэх изолятор гэмтсэн гэмтэл устгах ажлыг зохион байгуулж хийсэн.

T-2 110кВ-н трансформаторын термодатчик гэмтэлтэй байсныг. Үзлэг хийж термодатчикийн мэдрэгч нь цантаж норсон байсныг цэвэрлэгээ хийж хэвийн ажиллагаанд оруулсан байна.

110 кВ Айраг АШ-ын гэмтэлтэй байсан SATEC электрон хэмжүүрийг сольж хэвийн болгов. РМ-130 маркийн хэмжүүр суурилуулав

Багануур дэд станцад 35 кВ-н Р-1 болон 35 кВ-н Р-1-н таслуурын тосны түвшин тэгшитгэж 200 л тос нэмсэн.

110/35/6 кВ Бор-Өндөр дэд станцын 110/35 кВ-н гэмтэлтэй ЦШ-ын тоолуурыг шинэчлэх ажлыг зохион байгуулж хийсэн.

Дэд станцуудын тоноглолын халаагуурт үзлэг хийж гэмтэлтэй халаагуурыг тухай бүр нь сольж гэмтэл устгаж ажиллаж байна.

Ашиглалтын түвшин дээшлүүлэх ажлуудаас: Хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах, гэнэтийн болзошгүй аваар, саатлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шугам тоноглолд үзлэг хийх график гарган удирдлагаар батлуулж графикайн дагуу инженер техникийн ажилтнаар ахлуулсан бригад үзлэгийг 2023 оны 02 дугаар сарын 05 наас 10-ны өдрийн хооронд салбарын харьяа 220,110 кВ ЦДАШ-нд ээлжит үзлэгийг зохион байгуулж хийлээ.

Үзлэгийг Чойр хэсгийн засварын мастер Н.Наранбаяр, Э.Золбоо Сайншанд хэсгийн ашиглалт шуурхай үйлчилгээний инженер Л.Бямбадорж Өндөрхаан хэсгийн ашиглалт шуурхай үйлчилгээний инженер С.Одхүү, Чойр хэсгийн жолооч Д.Гансэлэм, Өндөрхаан хэсгийн жолооч С.Батсуурь, Сайншанд хэсгийн жолооч Б.Энхболд, Багануур хэсгийн жолооч Б.Алтангэрэл нар хийж гүйцэтгэв.

Нийт 19 ЦДАШ-нд үзлэг хийснээс 129 ширхэг гэмтэл илэрсэн байна. Дээрх гэмтлээс тасралтад нөлөөлөхөөр байсан дараах гэмтлүүдийг устгах ажлыг зохион байгуулж хийсэн байна.

Гэмтэл устгах чиглэлээр:

110 кВ Галуут-А,Б ЦДАШ-нд А№4-н II фазын шлейфны ПА хавчаарын 1 боолт унасан, Галуут-Б ЦДАШ-ын А№1 II фазын ПА хавчаарын 1 боолт унасан гэмтлийг 2023 оны 02 дугаар сарын 7-ны өдөр Багануур хэсгийн бригад гэмтэл устгах ажлыг зохион байгуулж хийсэн.

110 кВ-н Бор-Өндөр ЦДАШ-н Т№115 I фазад 7-8 ширхэг судал 2 цэгт тасарсан байсныг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр АГТ-н дагуу Чойр хэсгийн бригад гэмтлийг устгаж АШ-ын хэвийн найдвартай ажиллагааг хангасан.

110кВ-н Айраг АШ-ын Т№20-21-н хооронд I фазын дамжуулагч дээр бш судал тасарсан гэмтэл устгах ажлыг зохион байгуулж хийсэн.

Бусад гэмтэл нь агаарын шугамын тасралтад шууд нөлөөлөхөөр гэмтэлгүй тул 2023 оны урсгал засварын ажлаар хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

Мөн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан харьяа дэд станцуудыг ХХБ болон ОПУ-н гэрэлтүүлгийн хэлхээ сайжруулах ажил, машин механизмд техникийн үйлчилгээ хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна.



Гэрээт ажлын хүрээнд: Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК болон Монцемент Билдинг Материалс ХХК-ийн хооронд байгуулсан ашиглалт засварын гэрээний дагуу салбарын РХАХТ-ын албаны бригад, Сайншанд хэсгийн засварын бригад,110/35/10 кВ Сайншанд дэд станц, 110/6 кВ Булагт дэд станц болон Өргөн ДЦС-д тоноглол ээлжит хэмжилт, туршилт, РХА шалгах, 110 кВ Булагт ЦДАШ-нд дээд үзлэг хийж гэмтэл устгах ажлуудыг 2023 оны 03 дугаар сарын 17-20-ны өдрийн хооронд зохион байгуулж холбогдох тайлан гаргаж ажилласан байна.

СУРГАЛТ, БҮТЭЭМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖЛУУД:

2023 ОНД АЛБА, ХЭСЭГ, ДЭД СТАНЦУУДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН БАЙРНЫ СУРГАЛТУУД

2023 оны 01-р сарын 02-ны өдрөөс 01-р сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд алба, хэсэг, дэд станцуудын ажлын байрны ээлжит сургалт батлагдсан төлөвлөгөөний дагуу танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулагдав.

Төлөвлөгөөний дагуу нийт 268 цагийн сургалтад алба, хэсэг, дэд станцуудын 2761 ажилтан хамрагдсан. /Давхардсан тоогоор/ Дэлгэрэнгүйг хүснэгт-1-т харуулав.



Хүснэгт-1

д/д	Алба, хэсэг, дэд станц	Хугацаа [цаг]	Сургалтад хамрагдсан ажилтны тоо /Давхардсан тоогоор/
1	АШУА	24	750
2	Захиргаа аж ахуйн алба	15	104
3	Реле хамгаалалт хэмжилт туршилтын алба	56	102
4	Засварын алба	26	200
5	Чойр	50	550
6	Айраг	20	70
7	Сайншанд, Ширээт	36	400
8	Замын-Үүд, Борхойн	26	285
9	Өндөрхаан, Баянмөнх	20	120
10	Бор-Өндөр	37	180
НИЙТ		310	2761

Салбарын нэгдсэн ажлын байрны ээлжит сургалт:

2023 оны 01-р сарын 23-ны өдрөөс 01-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд салбарын хэмжээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 30 цагийн ажлын байрны ээлжит сургалтыг танхимын болон цахим хэлбэрээр хослуулан зохион байгуулав. Сургалтад салбарын хэмжээнд нийт 579 /давхардсан тоогоор/ ажилтан хамрагдсан. Үүнд:

Хүснэгт-2

д/д	Сургалтын чиглэл	Хугацаа [цаг]	Сургалтад хамрагдсан ажилтны тоо
1	ХАБЭА-н чиглэлээр	10	130
2	Реле хамгаалалт автоматикийн чиглэлээр	4	86
3	Цахилгаан тоног төхөөрөмжийн чиглэлээр	8	141
4	Шуурхай ажиллагааны чиглэлээр	4	62
5	Ажилтны ёс зүй хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр	4	160
НИЙТ		30	579

ГОВИЙН БҮСИЙН САЛБАР

ХАБЗА ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

Салбарын хэмжээнд 2022 оны 10, 11, 12 дугаар сарууд, 2023 оны 01, 02 дугаар сард нарыдаар 38, шийдвэрээр 116 ажил хийгдсэн. Наряд, шийдвэрээр ажил гүйцэтгэхэд ажлын аюулгүй байдлыг хариуцагчид болон бригадын бүрэлдэхүүнд онцгой анхааран, шат шатны зааварчилгааг чанартай өгч, хяналт тавьж ажилласан.

Салбарын хэмжээнд 45 удаагийн дасгал зохион байгуулагдаж 326 ажилтан хамрагдсан, сарын давтан зааварчилгааг 415 хүн, тухайлсан зааварчилгааг 582, ээлжит бус зааварчилгааг 518 хүнд өгч ажилласан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны үзлэгийг 980 удаа хийж 63 зөрчил, II шатны үзлэгийг 45 удаа хийж 78, III шатны үзлэгийг 2 удаа хийж 109 зөрчил илрүүлэн устгаж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллалаа. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 189 удаа хийж ажилласан.

2023 оны мэдлэгийн ээлжит шалгалтыг 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 03 дугаар сарын 06-ны өдрийн хооронд авч, нийт 73 ажилтан шалгалт өгсөн. Ажлын аюулгүй байдлыг хариуцагч нарыг салбарын даргын 2023 оны 03 сарын 01-ний өдрийн А/15 дугаар тушаалаар баталгаажуулсан.



АШИГЛАЛТЫН ТҮВШИН, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

СУРГАЛТ ДАДЛАГАЖУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны дарга Ч.Сугиртогтох ШУТИС дээр зохион байгуулагдсан “Мэргэшсэн инженерийн сургалт”-д амжилттай суралцаж мэргэшсэн инженерийн зэрэг авсан.

Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль дээр зохион байгуулагдсан “Шуурхай үйлчилгээний диспетчер” сургалтад Ашиглалт шуурхай үйлчилгээний албаны ахлах бөгөөд ашиглалт шуурхай үйлчилгээний инженер Б.Бүрэннэмэх, салбарын диспетчер инженер П.Ганцэцэг нарыг, Төвийн бүсийн салбарын сургалтын баазад зохион байгуулагдсан ашиглалт шуурхай, үйлчилгээний албаны ажилтнуудыг реле хамгаалалт автоматикийн чиглэлээр чадавхжуулах сургалтад ашиглалт шуурхай үйлчилгээний албаны Тавантолгой дэд станцын ээлжийн инженер Ш.Батсайхан, салбарын диспетчер инженер Б.Үүрийнтуяа нарыг, ЗӨБС-ын сургалтын төвийн “Чадамжийн гэрчилгээ” олгох ахисан шатны сургалтад АШУА-ны Даланзадгад дэд станцын ээлжийн монтёр Т.Амарбаясгаланг, “Цахилгаан дамжуулах агаарын шугамын засварын монтёр”-ын чадамжийн гэрчилгээ олгох сургалтад шугамын засварын монтёр И.Эрдэнэсоёлыг, Төвийн бүсийн салбарын сургалтын бааз дээр зохион байгуулагдсан “Реле хамгаалах автоматикийн монтёр”-ын чадамжийн гэрчилгээ олгох сургалтад РХАХТА-ны реле хамгаалалт, автоматикийн монтёр П.Лувсан-Иш, Л.Энх-Амгалан нарыг тус тус хамруулсан.

Төлөвлөгөөт бус сургалт, дадлагажуулалтын хүрээнд:

- Компанийн төсөвчдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад 10 дугаар сарын 03-ны өдрөөс 06-ны өдрийг дуустал хугацаанд инженерийн хэсгийн зураг төсвийн инженер Г.Содномцэрэн хамрагдсан.
- Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл”-н хүрээнд ЭХЯ болон төслийн багийнхан ШУТИС-тай хамтран “Эрчим хүчний салбарт ажиллаж буй эмэгтэй инженерүүдийг чадавхжуулах сургалт”-ыг 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хугацаанд анхан, дунд, ахисан шатны хэлбэрээр зохион байгуулсан. Уг сургалтад салбарын нийт 9 инженер техникийн эмэгтэй ажилтнууд хамрагдсан.
- Ашиглалтын ажилтнуудад зориулсан “Хэт улаан туяаны камерын оношилгоо” сэдэвт 6 цагийн цахим сургалтад салбарын 8 ажилтан хамрагдсан.
- Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн Сургалт үйлдвэрлэлийн төвөөс зохион байгуулж буй Анхан шатны нэгжид удирдах ажил хийж буй хүмүүст зориулсан 3 өдрийн мастерын сургалтад тус салбарын Засварын албаны дэд станцын засварын мастер Б.Баярсайхан хамрагдсан.

2023 оны Ээлжит сургалтыг ажилтнуудын ээлжийн горимд нийцүүлэн эхний хэсгийн ажилтнуудад Салбарын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/22 дугаар тушаалаар 2022 оны 12 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд, хоёрдугаар хэсгийн ажилтнуудыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 тушаалаар 2023 оны 01 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд батлагдсан хөтөлбөрийн дагуу танхимаар зохион байгуулсан. Сургалтыг ЦДҮС ТӨХК-ийн Улаанбаатар салбарын Ашиглалтын инженер Э.Бүрэнжаргал, Цэций СЦС-н РХА-н инженер Т.Цэнгэл, Normount LLC РХА-н инженер Л.Содномцэрэн, Гэрэлтдэг ертөнц ТББ-ын сургагч багш М.Санжаасүрэн болон салбарын инженер техникийн 10 ажилтан 22 сэдвийн хүрээнд 27 цагийн хичээлийг зааж давхардсан тоогоор 90 ажилтан хамрагдсан байна.


ӨНӨӨДРӨӨС ИЛҮҮГ СЭТГЭЖ ИРЭЭДҮЙГ ХАМТДАА БҮТЭЭЦГЭЭ



АШИГЛАЛТЫН ТҮВШИН ДЭЭШЛҮҮЛЭХ, НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖЛУУД:

215:216-р агаарын шугамын тулгуур №824-825-н хооронд автозамтай огтлолцож байгаа овор барихгүй хэсэгт ПС220-2 маркийн завсарын тулгуур босгох ажлын хүрээнд ФЗ-2 маркийн 4 ширхэг фундаментийг суурилуулж тулгуурыг өндөрлөх ажлыг салбарын ерөнхий инженерээр ахлуулсан 17 хүний бүрэлдэхүүнтэй бригад, 5 машин механизмтай 2022 оны 10 сарын 12-ны өдрөөс 13-ны өдрийг дуустал 3 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн.

Дундговь аймгийн нутгаар шуурсан хүчтэй шороон шуурганы улмаас 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр 215:216-р агаарын шугамын тулгуур №32 унаж аваарын нөхцөл байдал үүссэн. Учирсан гэмтлийг устгахаар Улаанбаатар салбарын засварын ахлах инженер С.Ариунбатаар ахлуулсан 5 салбарын 86 ажилтан, 17 машин механизмтай 215:216-р агаарын шугамын тулгуур № 32-ыг шинээр угсарч солих, 3 фазын дамжуулагч утас болон аянтын тросс татаж бэхлэх, тулгуур №30, 31 дээр гулзайсан деталиудыг тэгшлэх, бэхлэх ажлыг хийж түргэн шуурхай гүйцэтгэсэн.




ЦАГ ҮЕИЙН АЖЛААР:

Тус салбар нь 2022 оны туршид хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр компанийн хэмжээнд шалгаруулсан “Засвар, ашиглалтын ажлын чанарыг дээшлүүлэх уралдаан”-д Тэргүүн байрыг эзэлсэн. Мөн салбарын засварын албаны дэд станцын засварын монтёр Ө.Отгонзаяа компанийн “Хөдөлмөрийн аварга засварын монтёр”-оор шалгарч, “Ажлын байрны соёл-5С” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн Шилдэг дэд станцын гуравдугаар байранд 110/35/10 кВ Даланзадгад дэд станц шалгарч 2022 оноо амжилтаар дүүрэн үдсэн. Салбарын 2022 оны “Тэргүүний ажилтан”-аар Даланзадгад дэд станцын ээлжийн техникч Б.Бямбасүрэн шалгарч хамт олноо хошуучилсан.

Салбарын 10 жилийн ойг угтаж хамт олны нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх, багаар ажиллахад сургах, бүтээлч ажлын идэвхийг дээшлүүлэх зорилгоор ажилтнуудын төрсөн ордоор хуваарилсан багуудын дунд болзолт уралдааныг 6 сарын хугацаанд зохион байгуулсан. Уралдаанд оролцож байгаа багууд 6 сарын хугацаанд нийт 107 нэр төрлийн ажлыг төлөвлөн гүйцэтгэсэн байна. Болзолт уралдааны үр дүнгээр салбарын өнгө үзэмж сайжирч, тохижилтын ажлууд хийгдэж, ажилтнуудын бүтээлч хандлага, жигд оролцоог хангаж багаар ажиллах урам өгсөн онцлог ажил болсон. Уралдааны шалгаруулалтаар Тэргүүн байрыг “Нум-Хамтатгах” ордны хамтарсан баг, дэд байранд “Хилэнц-Матар”-ын ордны баг тус тус шалгарсан. Энэхүү болзолт уралдааныг 2023 онд үргэлжлүүлэн зохион байгуулж багууд хийх ажлын төлөвлөгөөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

Компанийн болон салбарын удирдлага зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийн талаар нийт ажилтнуудад мэдээлэл өгөх “Нийтийн мэдээллийн цаг”-ийг тогтмолжуулах зорилгоор 2023 онд нийт 18 удаа зохион байгуулахаар хугацааг товловсон. Батлагдсан хөтөлбөрийн дагуу 4 удаагийн нийтийн мэдээллийн цагийг зохион байгуулж ажилтнуудад цаг үеийн мэдээ мэдээлэл, хийгдсэн болон хийхээр төлөвлөж буй ажил, ажилтнуудын цалин нэмэгдэл, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн, ХАБЭА-н мэдээ, эрүүл мэндийн сургалт, зөвлөгөө зэргийг мэдээлсэн.





ТӨВ УДИРДЛАГА

КОМПАНИЙН 2023-2024 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАГДЛАА

Монголын Эрчим хүч, геологи, уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо, салбарын ажил олгогч эздийн байгууллага хооронд байгуулсан “Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт /тариф/-ын 3 талт хэлэлцээр”-ийг үндэслэн өнөөдөр компанийн Захиргаа болон Үйлдвэрчний эвлэлийн хороо 2023-2024 онд хэрэгжүүлэх Хамтын гэрээг байгууллаа. Гэрээнд ажил олгогчийг төлөөлж компанийн захиргаа, ажилтнуудыг төлөөлж компанийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга Ц.Мөнхбаатар, салбаруудын ҮЭХ-ны дарга нар, тэргүүлэгчид гарын үсэг зурж баталгаажууллаа. Энэ удаагийн хэлэлцээрээр хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарим нэмэлт өөрчлөлтүүд оруулж ажиллах асуудал дээр талууд санал нэгдсэн болно.

КОМПАНИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
“УЛААНБААТАР-2023” СПОРТЫН ТАВАН ТӨРӨЛТИЙН
ТЭМЦЭЭНД УЛААНБААТАР САЛБАР ТЭРГҮҮЛЛЭЭ

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК үүсэж хөгжсөний 55 жилийн ойн нэрэмжит “Улаанбаатар-2023” спортын таван төрөлт тэмцээн 2023 оны 03-р сарын 16, 17, 18-ны өдрүүдэд Төв удирдлагын спорт цогцолборт амжилттай болов.

Тус тэмцээнд Төв удирдлага болон 5 салбарын төлөөлөл 200 гаруй инженер, техникийн ажилтан авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс Улаанбаатар салбар багийн дүнгээр хошуучилж, шилжин явах цом авсан бөгөөд удаах байрыг Зүүн-Өмнөд, Төвийн бүсийн салбар эзэлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа.

БАГУУДЫН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОЖ ТӨРӨЛ БҮРТ БАЙР ЭЗЭЛСЭН БАЙДЛЫГ
ХАРУУЛСАН ХҮСНЭГТ

Д/д	Багуудын нэр	Сагсан бөмбөг		Волейбол		Теннис	Шатар	Дартс	Нийлбэр	Байр
		Эр	Эм	Эр	Эм					
1	Улаанбаатар	1	3	1	3	6	2	1	17	I
2	Зүүн-өмнөд бүсийн салбар	2	1	6	1	2	6	4	22	II
3	Төвийн бүсийн салбар	3	4	4	5	1	5	2	24	III
4	Говийн бүсийн салбар	4	5	3	2	3	3	6	26	IV
5	Төв удирдлага	5	6	2	4	4	4	3	28	V
6	Хангайн бүсийн салбар	6	2	5	6	5	1	5	30	VI

Мөн ахмадуудын дунд явуулсан биллъярдын тэмцээнд 20 гаруй тамирчин оролцож, Ахмадын хорооны дарга, биллъярдын спортын мастер Л.Дарамбазар тэргүүн байрт шалгарсан юм.

Энэхүү уламжлалт тэмцээний сагсан бөмбөгийн эрэгтэй шилдэг тоглогчоор Улаанбаатар салбарын З.Ганбаяр, эмэгтэй шилдэг тоглогчоор Зүүн-Өмнөд бүсийн салбарын Д.Баяржаргал, волейболын шилдэг эрэгтэй тоглогчоор Төвийн бүсийн салбарын Б.Наранбаатар, эмэгтэй шилдэг тоглогчоор Зүүн-Өмнөд бүсийн салбарын Р.Энхмаа нар шалгарч баг тамирчидыг манлайлав.

Хөгжөөн дэмжигчдийн дунд явуулсан сагсан бөмбөгийн 3 онооны шидэлтийн тэмцээнд удирдлагуудын ангилалд, Говийн бүсийн салбарын дарга Н.Бямбадорж тэргүүлсэн бол, ажилтнуудын ангилалд Улаанбаатар салбарын Ашиглалт, шуурхай үйлчилгээний албаны ахлах бөгөөд диспетчер инженер Х.Лхагвасүрэн шалгарлаа.

Компанийн гүйцэтгэх захирал Б.Дашдаваа дараа жилд спортын таван төрөлтийн тэмцээнийг ЗӨБС-т зохион байгуулах шийдвэр гаргаж, салбарын дарга Б.Ганбаяр талархан хүлээн авсан. Нийт тэмцээнд оролцсон баг тамирчид, ажилтан албан хаагчдад ажил хөдөлмөрийн болон спортын өндөр амжилт хүсье.

“ТУНАРАА ХҮНИЙ ХӨГЖИЛ ТӨВ”-ӨӨС СУРГАЛТ
ЛЕКЦ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Компанийн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос санаачилан 2023.03.10-нд Төв удирдлага болон Улаанбаатар салбарын ажилчдад “Тунараа хүний хөгжил төв”-ийн зөвлөх багш П.Тунараагаар лекц уншуулав. Тус төв нь “Нийтийн далд ухамсрыг сэргээх” зорилтын дор үйл ажиллагаа явуулдаг бөгөөд “Байгууллагын соёл”, “Албан харилцааны ёс зүй”, “Эерэг зөв хандлага”, “Хувь хүний хөгжил”, “Орчин цагийн залуусын харилцаа, хандлага”, “Ахмад, дунд, залуу үеүдийн ялгаатай сэтгэлгээ, ажилтнуудын дасан зохицох ур чадвар” сэдвүүдээр лекц уншиж, ажилтан албан хаагчидтай нээлттэй ярилцав. Сургалт, лекцийг УБЦТС ТӨХК-ийн хурлын зааланд зохион байгуулсан бөгөөд 100 гаруй ажилтан хамрагдсан.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕРИЙН НЭРЭМЖИТ
ӨВӨЛЖИЛТИЙН ЯВЦЫГ ШАЛГАХ АЖЛЫН
ХЭСЭГ АЖИЛЛАВ

Компанийн гүйцэтгэх захирлын 2022.12.14-ний өдрийн А/240 тоот тушаалаар томилогдсон “Ажлын хэсэг” Хангай, Төв, Зүүн-Өмнөд, Говийн бүс, Улаанбаатар салбаруудад их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтаар 2022 онд хийгдсэн томоохон ажлууд, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хэрхэн гүйцэтгэсэн байдал, дэд станцууд болон ажлын байрууд ХАБЭА, галын аюулгүй байдлыг хангаж ажиллаж байгаа болон компанийн нууцын сургалт, хичээлийг явуулан, тушаалаар өгөгдсөн үүргийг амжилттай хэрэгжүүлэн ажиллав.



“НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ”

БУЛАН

ТАЙЛБАР: Монгол Улсад цахилгаан дамжуулах сүлжээ үүсэж хөгжсөний нэгэн жарны түүхэн ой 4 жилийн дараа тохиох болно. Түүхийн үйл явцтай холбогдуулан Дамжуулах сүлжээ сонинд “НЭГЭН ЖАРНЫ ТҮҮХ” буланг Ахмадын хорооноос шинээр нээж техникийн дэвшил, түүнийг эзэмшигч хөдөлмөрийн хүмүүсийн тухай дугаар дараалан хамт олноо толилуулахыг зорьж байна.

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ БА ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМИЙН ҮҮСЭЛ

Ардын Сайд нарын Зөвлөлийн 1938 оны 5 дугаар сарын 6-ны 16 дугаар Хурлын тогтоолд ... 5 дугаар зүйл. Аж үйлдвэр, Барилгын яамны Сайд Тавхайгаас Улаанбаатар хотоос Налайхын чулуун нүүрсний уурхайн газар хүртэл цахилгаан гэрлийн шугам ба трансформаторыг байгуулах тухай илтгэснийг сонсоод Улаанбаатараас Налайх хүртэл тийнхүү цахилгаан гэрлийн шугам утас ба трансформаторыг байгуулах хэмээсэн нь зүйтэй тул ёсоор болгон баталж энэ тухай хурлаас гаргасан тогтоолыг тусгай хавсаргав. гэжээ. /УТТА ф -1, Т-2 х/н-68 131-р тал/. Аж үйлдвэр ба барилгын яамны 1938 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 121 тоот тушаалаар уг ажлыг Аж үйлдвэрийн комбинатаас хариуцан Богд уулнаас 1500 шон бэлтгэх, ажлыг дуусгаж 1939 оны 1 дүгээр сарын 1-нээс Налайхад гэрэл өгөхийг заажээ. Энэ тогтоол, тушаалын дагуу Улаанбаатар Налайхын хооронд 35 кВ-ын цахилгаан дамжуулах шугамыг барьж дуусган 1939 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулжээ. Дунд голын Цахилгаан станцын ХБ аас 6 кВ-ын хүчдэлийг 35 кВ болгон өсгөх зорилгоор ТМ 560 кВА чадалтай 35/6 кВ-ын дэд станц барьж Налайх хүртэл 35 кВ-ын шугамаар дамжуулж Налайхад мөн ижил чадалтай бууруулах дэд станц барьж Уурхайг тэжээжээ. Ийнхүү Монгол Улсад анх удаа 35 кВ-ын цахилгаан дажуулах шугам, 35/6 кВ-ын дэд станц, 6 кВ-ын ХБ ашиглалтад орсон нь Цахилгаан сүлжээний хөгжилд гарсан чанарын томоохон ололт, техникийн дэвшил байлаа. /Хөгжлийн түлхүүр УБ 2007 он X -11,12/ Ийнхүү тэр үеийн эрчим хүчний 2 том үйлдвэрийн хооронд бүтээгдүүнээ харилцан солилцох болсноор барахгүй нэг нь нөгөөгүйгээр ажиллах нөхцөлгүй тийм уялдаа холбоо бүхий түлш эрчим хүчний цогцолбор шинжтэй болжээ. /БНМАУ ын Түлш эрчим хүчний аж үйлдвэрийн хөгжилт УБ 1982 он X-67/



МАХН ын XIV их хуралаас БНМАУ-ын аж ахуй соёлыг 1961-1965 онд хөгжүүлэх III 5 жилийн төлөвлөгөөний удирдамжийг баталжээ. Улаанбаатар хотын Дулааны цахилгаан станцын хүч чадлыг 2,5 дахин нэмэгдүүлэх, Толгойтын районд Дулааны цахилгаан станц, Дарханы үйлдвэрийн районд 50000 кВт-ын хүчин чадалтай Дулааны цахилгаан станцын барилгын I ээлжийг дуусгахаас гадна Аймгийн төв томоохон суурин газруудад дунд зэргийн цахилгаан станц барих нийтдээ хөдөө орон нутагт 2000 аад жижиг дизель станц тавих замаар 1965 онд бүх цахилгаан станцын хүч чадлыг 1960 оныхоос 4,6 дахин нэмэгдүүлж цахилгаан гаргалтын хэмжээг 438,5 сая кВт/цагт хүргэхээр заажээ. Төлөвлөгөөний дагуу 1961 оны 12 дугаар сарын 26-нд Толгойтын цахилгаан станц /12 мВТ/ ын эхний ээлж ашиглалтад орж Ерөнхий инженерээр Н.Тогоо /АУГавъяат -хөшөөнд мөнхөрсөн/ ажиллаж байв. 1963 онд Төв цахилгаан станцын хүчин чадал V дахь өргөтгөлөөр 36 мВТ болжээ. 1964 оны 8 дугаар сард Толгойтын станц, Төв цахилгаан станцыг холбосон 35 кВ-ын цахилгаан дамжуулах сүлжээ ашиглалтад орсноор тус Улсын түүхэнд анх удаа Дулааны хоёр цахилгаан станц зэрэгцээ ажиллах болов.Түүнчлэн III-р 5 жилийн төлөвлөгөөний гол объект Дарханы Дулааны цахилгаан станцын барилга угсралтыг Зөвлөлт Холбоот Улсын хүч хөрөнгөөр богино хугацаанд дуусгаж 1966 оны 1 дүгээр сарын 15-нд эхний ээлжийг, Шарын голын уурхайн цогцолбор барилгыг 1965 оны 4 дүгээр сарын 6-нд ашиглалтад тус тус оруулжээ. Дархан-Шарын голын 110 кВ-ын агаарын шугам 102 км, 110/35/6 кВ, 110/6 кВ, 35/6 кВ-ын дэд станц 4 шинээр, 6 кВ-ын агаар, кабель шугам 4 км, 6/0,4 кВ-ын дэд станц 4 /нийт 640 кВА/, 0,4 кВ-ын агаарын шугам 3,5 км дээр нэмэгдсэн түгээх

сүлжээний ашиглалт үйлчилгээг хариуцуулахаар 1965 оны 4 дүгээр сарын 1-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 155 дугаар тогтоолоор Аж үйлдвэрийн яамны харьяа ДАРХАН-СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР-ыг байгуулжээ.Таван жилд Улаанбаатар хот болон төв суурин газарт 200 шахам км 35-110 кВ-ын өндөр хүчдлийн цахилгаан сүлжээ баригдсаны дотор Дархан-Шарын голын 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам 1963 онд, Дархан-Дулаанхаан, Сүхбаатар хотын 35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам 1965 онд ашиглалтад орсноор Дархан, Сүхбаатарын хотын Дулааны цахилгаан станцууд зэрэгцээ ажиллагаанд орж улмаар Монголд Хоёр дахь буюу орон нутгийн Эрчим хүчний систем үүсжээ. Ийнхүү манай орны төвийн районд ЗХУ-ын тусламжаар Монгол Улсын томоохон ил нүүрсний уурхай, Дулааны цахилгаан станц, өндөр хүчдлийн цахилгаан дамжуулах шугам шинээр баригдаж ашиглалтад орсон нь Түлш эрчим хүчний аж үйлдвэрийн Хоёр дахь том цогцолбор бүрэлдэж Эрчим хүчний систем үүсэх угтвар нөхцөл бүрэлджээ.

МАХН ын XV их хурлаар МАХН ын 4 дэхь программыг баталж БНМАУ ын ардын аж ахуй, соёлыг 1966-1970 онд хөгжүүлэх зорилтыг тодорхойлжээ. Намын программд ... Цахилгаан станцын хүч чадлыг нэмэгдүүлэх, цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам тавьж тус орны Эрчим хүчний төвлөрсөн систем байгуулах,чулуун нүүрсний орд ашиглах, түлш эрчим хүчний үйлдвэрийг илүү түргэн хурдацтай хөгжүүлэн хүн амын эрчим хүчний хэрэглээг улам сайн хангахаар заажээ. IV 5 жилийн төлөвлөгөөгөөр Улаанбаатарын Дулааны III цахилгаан станцын эхний ээлж, Дулааны II цахилгаан станцын 2 дахь ээлж, Дорнотын Дулааны цахилгаан станц, цахилгаан дамжуулах өндөр





ДАМЖУУЛАХ ӨНДӨР ХҮЧДЭЛИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ ҮҮССЭНИЙГ комисс дүгнэн ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮҮССЭН ӨДРИЙГ 1967 оны 7 ДУГААР САРЫН 5-НЫ ӨДӨР гэж тогтоожээ. Комиссын саналыг тус Компанийн Захирлын зөвлөлийн 2006 оны 5 дугаар сарын 23-ны хурлаар хэлэлцэж санал нэгдэн улмаар Түлш Эрчим хүчний яамны 2006 оны № 6/1416 тоотор дэмжигдсэн байна. Энэ тухай 1967 оны 7 дугаар сарын 5-нд Дархан-Улаанбаатарын 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам ашиглалтад орж анх удаа манай орны Төвийн районы Эрчим хүчний систем үүсжээ. /БНМАУ ынТүлш эрчим хүчний аж үйлдвэрийн хөгжилт УБ 1982 он X- 156-157/

ТӨВИЙН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ҮҮССЭН АНХНЫ СХЕМ

Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх V, VI 5 жилийн төлөвлөгөөний удирдамжинд Түлш эрчим хүчний аж үйлдвэрийг илүү хурдацтай хөгжүүлэхээр заасан нь биелэлээ олж техникийн шинэ дэвшил нэвтэрч чанарын томоохон өөрчлөлт ирэв.

Цахилгаан Дамжуулах Шугам сүлжээ үүссэн анхны схем 1967.07.05





1976 онд Зөвлөлт Холбоот Улсын Галуут нуур-Дарханы 220 кВ-ын цахилгаан дамжуулах шугам 220/110/35 кВ-ын 2х63 мВА дэд станц анх ашиглалтад орж ТЭХС нь ЗХУ-ын Сибирийн Эрчим Хүчний Системтэй зэрэгцээ ажиллагаанд орсон нь манай орны Эрчим хүчний салбарын хөгжилд түүхэн ач холбогдолтой чухал үйл явдал болжээ. 1971-1980 онуудад Дамжуулах шугам сүлжээ ихэвчлэн төвийн бүсийн баруун, хойд чиглэлд давамгайлан хөгжиж энэ үед Дархан – Эрдэнэтийн 220 кВ-ын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц түүнээс салбарлан Эрдэнэт-Хялганатын 110 кВ-ын шугам дэд станц, Эрдэнэт-Булганы 110 кВ-ын 2 хэлхээт шугам дэд станцын хамт ажиллагаанд орж Булган аймаг ТЭХС-д холбогдож Дизель станцаас ангирчээ. Дарханы цахилгаан станцаас Ерөө, Бугант, Толгойтын 110 кВ-ын шугам дэд станцууд, Улаанбаатар Дулааны станц III-Өмнөт-Туулын 110 кВ-ын хос шугам, 110/6 кВ-ын 2х16 мВА Өмнөт 110/35/10 кВ-ын 2х25 мВА Туул дэд станцууд ашиглалтад орж Дамжуулах сүлжээ хүрээгээ тэлж хөгжжээ. Монголын төвийн районд цахилгаан дамжуулах сүлжээ өргөжин улмаар түгээх сүлжээ бүрэлдэн хэрэглэгчдийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулан 1980 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 377 дугаар тогтоолоор Эрдэнэт Булганы Цахилгаан шугам сүлжээний газрыг байгуулжээ.

Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх VII, VIII 5 жилийн төлөвлөгөөий 1981-1990 онуудад Монголын Эрчим хүчний салбар түүний дотор дамжуулах шугам сүлжээний хөгжлийн хувьд урьд өмнө нь байгаагүй өргөжин тэлсэн, Төвийн бүсийн районыг бүхэлд нь хамарсан хөгжлийн оргил үе нь байжээ.Тухайлбал манай улсын хамгийн том хүчин чадалтай Дулааны IV цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулжээ. Түүнчлэн Улаанбаатар-Дарханы 220 кВ-ын шугам, Улаанбаатар-Эрдэнэтийн 220 кВ-ын 2 хэлхээт өндөр хүчдлийн шугам, Улаанбаатар-Багануур-Чойрын 220 кВ-ын 300 км шугам, 220/110/35 кВ-ын 500 мВА нийлбэр чадлын 3 дэд станц баригдаж ашиглалтад оржээ. Эдгээр он жилүүдэд Нийслэл хотод 110/35/10 кВ-ын Яармаг, Дорнот 2, Налайх, 110/35/6 кВ-ын Үйлдвэр, 110/6 кВ-ын Гео 110/10 кВ-ын Баруун, Улаанхуаран, 110/10/6 кВ-ын Умарт дэд станцуудыг холбосон өндөр хүчдлийн шугамын хамт баригдаж Нийслэл хотод 110 кВ-ын цагариг схем бүрэлдэх урьдчилсан нөхцөл бүрджээ. Багануурт Хот, Галуут, Төв, Уулын 110 кВ-ын шугам, 110/6 кВ-ын дэд станц, Чойроос

Бор өндөр, Хар айргийн 110 кВ-ын шугам, 110/35/10 кВ-ын дэд станц, Баянмөнх сумын 110 кВ-ын шугам,110/6 кВ-ын дэд станц шинээр баригдаж ашиглалтад орсноор Дамжуулах сүлжээ төвөөс Зүүн болон Өмнөт чиглэлд өргөжин хөгжиж өөрийгөө дагуулан шинэ шинэ цахилгаан түгээх сүлжээг үүсгэжээ. Ашиглалтын үйл ажиллагааг Төвөөс явуулах, хянахад хэт алслагдсан болон уул уурхайн томоохон хэрэглээ бий болсонтой холбогдуулан УБЦШСГ-ын Багануурын салбарыг өргөтгөн 1984 онд БНМАУ ын Сайд нарын Зөвлөлийн 328 дугаар тогтоолоор Багануурын Цахилгаан шугам сүлжээний газарыг байгуулжээ. Эдгээр он жилүүдэд баруун, хойт чиглэлд Дархан-Хөтөл, Баясгалантын 110 кВ-ын шугам, 110/35/6 кВ-ын дэд станц, Улаанбаатар-Эрдэнэтийн 220 кВ-ын 2 хэлхээт шугам, Булган-Хархорин, Булган-Хишиг-өндөр, Хархорин-Цэцэрлэг, Хархорин-Арвайхээр, Сансарын 110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам 110/35/10 кВ-ын дэд станцууд ашиглалтад оржээ. Ингэж Дамжуулах сүлжээ тухайн үедээ хөгжлийнхөө оргил үед хүрч өөрөөсөө 4 цахилгаан сүлжээг төрүүлжээ.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн 1991-2000 оны хооронд Дамжуулах сүлжээг өргөтгөх, шинэчлэх чиглэлээр улсаас хийх хөрөнгө оруулалт саармагжин мэдэгдэхүйц багассан боловч урьд нь төлөвлөсөн болон эхэлсэн ажлуудаа үргэлжлүүлэн хийж амжилттай дуусгасан юм. Тухайлбал Нийслэл хотод 110/35/10 кВ-ын Цэвэрлэх дэд станц, 110/10 кВ-ын Улаанхуаран дэд станц 110 кВ-ын цахилгаан дамжуулах салбар шугамууд шинээр баригдаж дуусган ашиглалтад оруулснаас гадна Дорнот 2 110/35/10 кВ-ын дэд станц, Улаанбаатар 220/110/35 кВ-ын дэд станцын 110 кВ-ын ИлХБ-уудыг өргөтгөн 110 кВ-ын шугамаар холбосноор Дулааны III цахилгаан станц - Дулааны IV цахилгаан станц - Баруун, Умарт, Дорнот 2, Улаанхуаран-Улаанбаатар, Амгалан, Туул, Өмнөт-Дулааны III цахилгаан станц гэсэн 110 кВ-ын 2 хэлхээтэй цагариг схем бүрэлдсэн нь Нийслэлийн цахилгаан хангамж эрс дээшилсэн бахархмаар сайхан амжилт болсон юм. Ер нь Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн хүнд үед Эрчим хүчний салбар тасралтгүй хөгжиж байсан бөгөөд түүний дотор Дамжуулах сүлжээ өргөжин тэлж схем хангамж, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж үндсэн үүргээ амжилттай

биелүүлж ирснийг бахархан тэмдэглэх нь зүйтэй. Дархан хотод Тосгон, Үйлдвэр, Дулаанхааны 110/6 кВ-ын дэд станц, Багануур-Зүүн өмнөт бүсийн чиглэлд Мандалговь, Өндөрхааны 110 кВ-ын шугам 110/35/10 кВ-ын дэд станцууд ашиглалтад орж эдгээр аймгууд төвлөрсөн Эрчим хүчний системд холбогдож цахилгаан хангамж нь найдваржжээ.

2000 он гарсаар Дамжуулах шугам сүлжээний сэргэн мандалтын шинэ үе эхэлж онцгой үйл явдал,чухал эрхийн акт, бүтцийн өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага нь тодорхой болсон юм. Монгол Улсын их хурлаас Эрчим хүчний салбарыг зах зээлийн нийгмийн тогтолцоонд нийцүүлэн 2001 оны 2 дугаар сарын 2-ны өдөр “Эрчим хүчний тухай хууль” шинэчлэн баталж Дамжуулах сүлжээний нэр томьёоллыг хуульчлан тодотгосон. Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15-д заахдаа “Цахилгаан дамжуулах сүлжээ”-нд цахилгаан дамжуулах зориулалт бүхий 110 кВ, түүнээс дээш хүчдэлийн шугам, дэд станц, түүнчлэн энэ сүлжээнд холбогдсон, эсхүл техник технологийн хувьд энэ сүлжээнд хамрагдах шаардлагатай бусад хүчдэлийн шугам, дэд станцыг хамааруулан заажээ. Мөн Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д... Дамжуулах сүлжээний хамрах хүрээг тогтоох эрхийг Засгийн газарт олгосны дагуу Монгол улсын Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолын 2 дугаарт “Төвийн бүсийн Цахилгаан дамжуулах сүлжээ” Төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагааны хамрах хүрээг “Улаанбаатар хот, Багануур дүүрэг, Дархан уул, Сэлэнгэ, Төв, Булган, Орхон, Архангай, Өвөрхангай, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Дундговь аймгийн нутагт байгаа 110 кВ-оос дээш цахилгаан дамжуулах шугам түүний дэд станцууд мөн Систем үүсгэж байгаа бусад шугам сүлжээ” гэж тодотгон заажээ. Төвийн бүсийн Цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК нь Улаанбаатар, Дархан-Сэлэнгэ, Эрдэнэт-Булган, Багануур зүүн өмнөт бүсийн Цахилгаан шугам сүлжээний газруудын эзэмшлээс тусгаарлан авсан 110 кВ ба түүнээс дээш хүчдлийн цахилгаан дамжуулах шугам дэд станцуудаас бүрдсэн 12,04 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөтэй 650 гаруй ажиллагсадтай үйл ажиллагаагаа 2001 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхэлсэн билээ. /Хөгжлийн түлхүүр УБ 2007 он Хуудас 16-21\

МЭДЭЭЛЛИЙГ БЭЛТГЭСЭН: КОМПАНИЙН АХМАДЫН ХОРООНЫ ДАРГА

"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК"-ИЙН ХҮНДЭТ АЖИЛТАН, АУГА Л.ДАРАМБАЗАР

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ ТӨХК-ИЙН АХМАДЫН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д бүртгэлтэй ахмад настны нийтлэг эрх, эрүүл мэнд, нийгмийн хамгаалалд чиглэсэн компанийн болон салбаруудын ахмадын хороо, ахмадын хорооны удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2 Энэхүү журам нь Ахмад настны тухай хууль, Монголын ахмадын холбооны дүрмийн заалтуудыг хэрэгжүүлэхэд компанийн хэмжээнд үйлчилнэ.

Үйл ажиллагааны зарчим

Ахмад настны тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Монголын ахмадын холбооны дүрмийн заалтуудыг мөрдлөг болгоно.

2.2 Ахмадын хорооны удирдах зөвлөл нь ахмад настны эрэлт хэрэгцээ, амьдрал, ахуй, эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх жилийн төлөвлөгөөтэй ажиллана.

2.2.1 Ахмадын хорооны удирдах зөвлөл, салбар хороодын жилийн төлөвлөгөө нь нийт гишүүдийн санал, хүсэлт эрмэлзэлд тулгуурлах бөгөөд байгууллагын ажлын чиглэлтэй уялдана. Төлөвлөгөөнд ахмад настны хөдөлмөр, бүтээл, мэргэжлийн ур чадвар, туршлага зэргийг ажлын хамт олонд танилцуулан, зөвлөгөө, сургаал хүртээх хүндэтгэлийн (Хөдөлмөрийн алдар, Эрчим хүчний ажилтны өдөр, Олон улсын ахмадын өдөр) уулзалтыг үндсэн ажлын хамт олны санаачилгаар тогтмол зохион байгуулахаар тусгагдвал зохино;

2.2.2 Ахмадын хорооны удирдах зөвлөл, салбар хороодын жилийн ажлын төлөвлөгөөг тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж гүйцэтгэх захирал, салбарын даргын тушаалаар батлуулж хэрэгжүүлнэ;

2.3 Ахмадын хорооны удирдах зөвлөл, салбар хороодын үйл ажиллагаа ил тод нээлттэй, тэгш хүртээмжтэй байна.

3. Ахмадын хорооны зохион байгуулалт

3.1 Ахмадын хороо нь Ахмадын хорооны удирдах зөвлөл, Төв удирдлага, Улаанбаатар, Хангай, Төвийн, Зүүн-Өмнөд, Говийн бүсийн салбарын ахмадын хороо гэсэн бүтэцтэй байна. Ахмадын хорооны бүтэц, ахмадын хорооны удирдах зөвлөл, Төв удирдлагын ахмадын хорооны бүрэлдэхүүнийг ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар батална.

3.2 Ахмадын хорооны дарга нь Ахмадын хорооны удирдах зөвлөлийн дарга байх бөгөөд ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар томилно.

3.3 Ахмадын хорооны даргыг тэргүүлэгчдийн хурлаар сонгоно.

3.4 Ахмадын хорооны удирдах зөвлөл нь орон тооны бус 11 гишүүнтэй байна. Гишүүдийн бүрэлдэхүүнд Төв удирдлага, салбаруудын ахмадын хорооны дарга, Захиргаа удирдлагын болон Санхүү, эдийн засгийн хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд томилогдон ажиллана. Гишүүдийн бүрэлдэхүүнийг ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар батална.

3.5 Салбар хороодын даргыг нийтийн хурлаар сонгож, салбарын даргын тушаалаар батална.

3.6 Салбар хороодын тэргүүлэгчдийн бүрэлдэхүүн нь орон тооны бус 5 тэргүүлэгчтэй байх бөгөөд салбар хороодын тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнийг салбарын даргын тушаалаар батална.

3.7 Ахмадын хорооны удирдах зөвлөл, салбар хороод нь харьяаллын байгууллагын Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой нягт хамтран ажиллана.

4. Ахмадын хороо, зөвлөлийн гүйцэтгэх үүрэг

4.1 Ахмадын хорооны удирдах зөвлөл, салбар хороод нь Ахмад настны тухай хууль, Ахмадын холбооны дүрэм болон Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн

Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-ний заалтуудыг бүрэн хэрэгжүүлэх Ахмад настны тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Монголын ахмадын холбооны дүрмийн заалтуудыг мөрдлөг болгоно.

4.2 Ахмад настны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь тусламж, дэмжлэг үзүүлэх, ахмад настны санал, санаачилгыг дэмжин бодит хувь нэмэр болох ажлуудыг зохион байгуулах.

4.3 Ахмад настны талаарх баримтлах бодлого, холбогдох эрх зүйн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, санаачилга гаргах, хууль тогтоомжийн дагуу тухайн асуудлыг компанийн удирдлагад уламжлах.

4.4 Эмчилгээ, сувилгаа шаардлагатай ахмад настныг дарааллын дагуу рашаан сувилал, нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээнд хамруулах.

4.5 Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн (Цагаан сар), Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан ахмад настнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг холбогдох нэгжүүдтэй хамтран зохион байгуулах.

4.6 Ахмад залуу үеийн холбоог сайжруулах, ахмад настнаас суралцах, ажлын дадлага туршлагыг өвлүүлэх, халамжлан хүмүүжүүлэх ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэх.

4.7 Ахмад настанд олгосон тэтгэмж, тусламж, үзүүлсэн үйлчилгээ түүнд зарцуулсан хөрөнгийн тайланг жилийн эцсээр гаргаж, компанийн удирдлага, ахмад настнуудад тайлагнах.

4.8 Харьяалагддаг орон нутгийн хороо, дүүргийн болон олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах.

4.9 Ахмад настны эрчим хүчний салбарт оруулсан хөдөлмөрийн бүтээл, ажлын амжилт, туршлагыг ажлын байранд, ЦДҮС ТӨХК-ийн болон төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлан таниулах.

5. Ахмадын хорооны зөвлөлийн сан

5.1 Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг болон “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 заалт, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.17 дахь хэсгийг тус тус үндэслэн Ахмадын хорооны санг цалингийн сангийн нэг хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр байгуулж, зарцуулалтыг гүйцэтгэх захирлын тушаалаар зохицуулна.

5.2 Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн ахмадын (уг журмын 5.1-д тогтоосон) сан нь төв удирдлага, салбаруудын ахмадын хороонд бүртгэлтэй ахмад настны тоог жишин хуваарилагдана.

5.3 Төв удирдлага, салбаруудын ахмадын хороо, зөвлөл нь Ахмадын санг төлөвлөн жил бүрийн үндсэн бус үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөнд тусгуулна. Ахмадын сан нь үйл ажиллагааны орлого дотоод, гадаадын байгууллага, иргэдийн хандив тусламжаар нэмэгдүүлж болно.

5.3 Ахмадын хороо, зөвлөлийн сан нь (Ахмадын сангийн журмын дагуу) дансны үлдэгдэл хөрөнгө, банкны хадгаламжийн хүүгийн орлогоор нэмэгдүүлж болно.

5.4 Ахмадын сан нь Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэгт заасан арга хэмжээнд жилийн төлөвлөгөөний ажилд зарцуулагдана.

5.5 Ахмадын сангийн төлөвлөлт, зарцуулалтын тайланг харьяаллын ахмадын хороо, зөвлөл нь тухайн нэгжийн захиргааны,санхүүгийн хэлтэстэй хамтран гаргаж, тайлагнана.

5.6 Ахмадын сангийн зарцуулалтыг компани, салбаруудын удирдлага хянаж жилийн эцэст гарын үсгээр баталгаажуулна.